**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны нэгдсэн байр,
Баянголын гудамж 1, 27 дугаар хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18082
Утас: (976) 7017 0109
Цахим хуудас: www.shd.mn

2024.11.21 № 03/3169

танай ____________ -ны № ____________ -т

ТӨГС ШИЙДЭЛ ОЙЛ ХХК-Д

Мэдэгдэл хүргүүлэх тухай

"Тохижилт, бүтээн байгуулалтын ажил (СХД)" НХААГ/20240101639 тоот тендер шалгаруулалтад ирүүлсэн танай тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэгт заасныг үндэслэн дараах шаардлагыг хангаагүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

| № | Захиалагчийн тавьсан шаардлага | Оролцогчийн санал | Шалгараагүй тухай тайлбар |
|---|---|---|---|
| 1 | ТШЗ 18.1 Техникийн чадавх болон туршлагын шаардлага: ***"Шаардана"***<br><br>Ажил гүйцэтгэх хүний нөөц: ***"Шаардана"*** Барилгын инженер, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь тухайн аж ахуйн нэгжийн үндсэн ажилтан байна. Бусад инженер техникийн ажилчид гэрээт байж болно. Гэрээт ажилтан бол тухайн төсөл, арга хэмжээнд зориулан хөдөлмөрийн гэрээ хийсэн байна. Гэрээтээр ажиллах бол хөдөлмөрийн гэрээг зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, хөдөлмөрийн хөлс зэргийг тодорхой тусгана.<br><br>Ажилласан жилийн туршлагыг нотлохын тулд Ус хангамж ариутгах татуургын инженер нь 24 сар, бусад инженер техникийн ажилчид 12 сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх ТҮЦ машины тодорхойлолтыг ирүүлнэ. | Санал болгож ирүүлсэн. | Санал болгож буй хүний нөөцийн ажилласан жилийн туршлага нотлох нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаа ирүүлээгүй.<br><br>ХАБЭАА-нь тухайн компанийн үндсэн ажилтан биш байна. |
| | ТШЗ 18.1 Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: ***"Шаардана" IV бүлгийн Маягт 2, Маягт 3-ын дагуу ирүүлэх.***<br>Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн **70 хувиас** багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг **2021, 2022, 2023** оны**...** | | Тухайн ажлыг чанартай хийж |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | **2022, 2023** онуудын **аль нэг жилд** доод тал нь **1 удаа** ижил, төстэй ажлын **үндсэн гүйцэтгэгчээр** ажилласан байх. **/Ижил төстэй ажил нь санхүүгийн тайланд тусгагдсан байна./**<br>-Ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар **/Гэрээний дагалдах материал бүрэн ирүүлэх/**<br>-Комисс хүлээн авсан дүгнэлтийн эхээс хийсэн хуулбар<br>-Тухайн ажлыг чанартай хийж гүйцэтгэсэн тухай захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ. | Ирүүлсэн. | гүйцэтгэсэн тухай захиалагчийн тодорхойлолтыг ирүүлээгүй. |
| 3 | ТШЗ 18.2 Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг: “Шаардана”<br><br>Ажлын зураг, ажлын тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэнэ. Магадлашгүй ажлын зардал, норм нормативын сангийн зардлыг төсөв зохиох зааврын дагуу, татвар хураамжийг холбогдох хуулийн дагуу тус тус тооцож ирүүлнэ. | Ирүүлсэн. | Санал ирүүлсэн 09-510-05 дугаартай ажлын тоо хэмжээг иж бүрдэл гэж ирүүлсэн нь өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй таарахгүй байгаа тул татгалзаж байна. |

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалтыг үндэслэн танай байгууллагын ирүүлсэн тендерээс татгалзаж, тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулах болсныг үүгээр мэдэгдэж байна.

Сонгинохайрхан дүүргийн засаг даргын тамгын газар ТБАГУТҮГ
Удирдлага
Тамгын газрын дарга
Долгор Төмөрбаатар
2024.11.21 14:55